



Аудитын код: САГ-2017/20/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Тээвэр, шатахууны зардлын талаар	8
2.9.2	Хувь хүний орлогын албан татварын талаар	8
2.10	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.12	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Тээвэр шатахууны зардлын талаар	11
3.2	Хувь хүний орлогын албан татварын талаар	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмчийн тайлан	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.ЦОГОО ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төрийн албаны зөвлөлийн дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG30.Docx

070189

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн тээвэр шатахууны зардал, хувь хүний орлогын албан татварын талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 5-наас 2017 оны 4 дүгээр сарын 24-ний хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 342 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг тус бүр мөрдөн ашиглаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны төв байгууллага бөгөөд хамтын удирдлагын зарчмаар ажиллаж, төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг улсын хэмжээнд нэгдсэн аргачлалаар хангах, хэрэгжүүлэх ажлыг эрхэлдэг, үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнадаг хараат бус, бие даасан байгууллага юм. Төрийн албаны зөвлөл нь Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн “Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай” 70 дугаар тогтоолоор Ажлын албаны орон тооны хязгаар нь 14 байхаар батлагдсан.

Үүнд: Дарга 1, ахлах референт 5, даргын туслах 1, референт 3, шинжээч 2, нягтлан бодогч-эдийн засагч 1, бичиг хэрэг, архивын эрхлэгч-бичээч 1 байхаар баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг:

- төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- төрийн албаны шинэтгэлийн стратегийн төлөвлөлт,
- төрийн боловсон хүчний бодлогын удирдамжаар хангах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах,
- төрийн жинхэнэ албан хаагчийн маргааныг хянан шийдвэрлэх, хууль тогтоомжийн актад нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх, биелэлтийг нь хангах, төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох,
- төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдолтой шаардлагатай мэдээллээр төр, засгийн удирдлагыг мэдээллээр хангах,
- төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах,
- төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах,
- төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах ,

Төрийн албаны зөвлөлийн эрхэм зорилгыг “иргэдэд ойр, уян хатан, идэвхитэй, санаачлагатай бөгөөд цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн манлайлагч менежер бүхий төрийн албыг бүрдүүлэхэд оршино”, гэж тодорхойлсон байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Төрийн албаны зөвлөлийн даргын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 5 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байгаа ч УСНББОУС, хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ

Төрийн албаны зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Emerald” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг

боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлийн дарга нь 2016 онд улсын төсвөөс 498.2 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр 498.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 498.0 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн төсвийн зарцуулалт:

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвөөс 2016 онд цалин, унаа хоолны хөнгөлөлтөнд 296.1 сая, байр ашиглалтын үйлчилгээнд 69.0 сая, нийгмийн даатгалийн шимтгэлд 32.6 сая, байрны түрээс 22.4 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 20.7 сая, тээвэр шатахууны зардалд 16.2 сая, албан томилолтод 12.5 сая, мэдээллийн технологийн үйлчилгээнд 11.2 сая, шуудан холбооны зардал 5.9 сая, бичиг хэргийн зардалд 5.6 сая, зөвлөлийн гишүүдийн ажлын хөлсөнд 2.9 сая, биеийн тамирын уралдаан тэмцээнд 1.1 сая, эд хогшил худалдан авах 0.5 сая, урсгал зардал 0.5 сая, мэдээлэл сурталчилгааны зардалд 0.4 сая, тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношлогоонд 0.4 сая, нийт 498.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Өглөгийн талаар:

Өглөгийн тодруулгаар өмнөх онд 8.9 сая төгрөгийн өглөгтэй ба тайланд онд 13.5 сая төгрөгийн тооцоо хийгдэж, 13.9 сая төгрөгийн өглөг төлөгдөж, оны эцэст 8.5 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Тухайлбал Засгийн газрын авто баазад 6.1 сая, Монгол шуудан ТӨХК-д 1.0 сая, Монгол ньус ХХК-д 0.6 сая, Өдрийн мэдээ ХХК-д 0.4 сая, Засгийн газрын хэвлэх үйлдвэрт 0.4 сая төгрөгийн өртэй тухай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

- Төрийн албаны зөвлөл нь шилэн дансны нэгдсэн вэб сайт болох www.shilendans.gov.mn болон өөрийн байгууллагын www.csc.gov.mn вэб сайтуудад Төрийн албаны зөвлөлийн бүтэн жил, хагас жил, улирал, сар, тухай бүрийн мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох мэдээллийг тогтмол байршуулж хэвшсэн. 2016 оны 4, 10-р саруудад Үндэсний аудитын газраас Шилэн дансны аудитад хамрагдаж зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Шилэн дансны нэгдсэн вэб сайтад байршуулсан мэдээлэл

№	Оруулах мэдээллийн хугацаа	Оруулах мэдээллийн тоо	Оруулах мэдээллийн тоо	Оруулсан мэдээллийн тоо
1	Бүтэн жилээр оруулах мэдээлэл	17	17	15
2	Хагас жилээр оруулах мэдээлэл	5	5	5
3	Улирал бүр оруулах мэдээлэл	2	8	8
4	Сар бүр оруулах мэдээлэл	5	60	60
5	Тухай бүрт нь оруулах мэдээлэл	8	96	96
	Нийт мэдээллийн тоо	37	186	184

Шилэн дансны нэгдсэн вэб сайтад 186 мэдээлэл оруулахаас 184 мэдээллийг байршуулсан байна.

2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн учир аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулах шаардлагагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг байршуулаагүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Тээвэр, шатахууны зардлын талаар

Даргын тушаал, төсөв, анхан шатны бэлэн мөнгөний баримтууд, томилолтоор ажилласан тайлан, томилолтын хуудас зэрэг баримтгүйгээр Засгийн газрын авто бааз руу шилжүүлж өдөр тутмын унааны зардлын баримт хавсарган 5.2 сая төгрөгийг албан томилолтоор тооцон шууд зардалд бүртгэсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөж ажиллах, зөвлөмж өгөх;

2.9.2 Хувь хүний орлогын албан татварын талаар

2016 онд ажиллагсдад хөнгөлөлт үзүүлж хоолны үнэнд 13.1 сая, унаанд 2.3 сая, нийт 15.4 сая төгрөг олгосон байна. Дээрх шууд бус орлогоос хувь хүний орлогын албан татварыг 9 хувиар тооцож суутган 0.2 сая төгрөгийг дутуу суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна", 15.1.1-д "үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө", 15.1.3-д "бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор", 23 дугаар зүйлийн 23.1-д "Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмж өгөх;

2.10 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 2 зөвлөмж өгсөн байна.

2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна

2.12 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 584.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 5.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 ТЭЭВЭР ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Даргын тушаал, төсөв, анхан шатны бэлэн мөнгөний баримтууд, томилолтоор ажилласан тайлан, томилолтын хуудас зэрэг баримтгүйгээр Засгийн газрын авто бааз руу шилжүүлж өдөр тутмын унааны зардлын баримт хавсарган 5.2 сая төгрөгийг албан томилолтоор тооцон шууд зардалд бүртгэсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Батлагдсан төсвөөс гадуур зарцуулалт гаргах, төсвийг үр ашиггүй зарцуулах,

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж, тайлант хугацааны эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан тайланд тусгаж хэвших;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.2 Хувь хүний орлогын албан татварын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 онд ажиллагсдад хөнгөлөлт үзүүлж хоолны үнэнд 13.1 сая, унаанд 2.3 сая, нийт 15.4 сая төгрөг олгосон байна. Дээрх шууд бус орлогоос хувь хүний орлогын албан татварыг 9 хувиар тооцож суутган 0.2 сая төгрөгийг дутуу суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д."Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна",15.1.1-д "үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө", 15.1.3-д "бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор", 23 дугаар зүйлийн 23.1-д."Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Илүү цалин олгох, албан татвар дутуу төлөх, албан татварын алданги, торгууль төлөх,

ҮАГ-ын зөвлөмж

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,747.2	15,475.4
БАРАА МАТЕРИАЛ	17,747.2	15,475.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	192,559.7	190,702.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	192,559.7	190,702.0
Биет хөрөнгө	192,557.9	190,702.0
Биет бус хөрөнгө	1.8	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	210,306.9	206,177.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,905.9	8,486.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,905.9	8,486.6
Өглөг	8,905.9	8,486.6
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	201,401.0	197,690.8
Засгийн газрын хувь оролцоо	201,401.0	197,690.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,739.6	434,739.6
Хуримтлагдсан үр дүн	(234,208.1)	(237,918.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869.5	869.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	210,306.9	206,177.4

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	668,722.4	580,035.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,339.0	81,845.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	602,383.4	498,189.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	693,842.4	584,717.4
УРСГАЛ ЗАРДАЛ	693,842.4	584,717.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,027.1	584,535.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,924.1	296,065.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,017.6	32,567.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,175.4	20,485.6
Хангамж, бараа материалын зардал	42,527.3	31,025.9
Эд хогшил, урсгал засварын зардал	711.5	1,761.8
Томилолт, зочны зардал	27,410.3	11,238.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,752.2	84,890.2
Бараа үйлчилгээний бусад зардал	121,508.8	106,500.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,815.3	181.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(25,120.0)	(4,682.3)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	972.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	972.2
НИЙТ ҮР ДҮН	(25,120.0)	(3,710.1)

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,520.9		226,520.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,520.9		226,520.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
Тайлант үеийн үр дүн	(25,120.0)		(25,120.0)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,401.0		201,401.0
2016 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	201,401.0		201,401.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,401.0		201,401.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-
Тайлант үеийн үр дүн	(3,710.1)		(3,710.1)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,690.8		197,690.8

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	602,383.4	498,189.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	602,383.4	498,189.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	602,383.4	498,189.9
УРСГАЛ ЗАРДАЛ	602,383.4	498,189.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,568.1	498,008.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,924.1	296,065.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,742.1	32,567.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,085.7	22,445.8
Хангамж, бараа материалын зардал	34,327.0	27,812.3
Эд хогшил, урсгал засварын зардал	731.5	848.6
Томилолт, зочны зардал	27,410.3	12,560.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,752.2	83,882.2
Бараа үйлчилгээний бусад зардал	38,595.3	21,825.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,815.3	181.8

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ			
	БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,065.6	296,065.4	(0.2)	100.0
Үндсэн цалин	276,754.0	276,753.8	(0.2)	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	19,311.6	19,311.6	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,567.3	32,567.3	-	100.0
Тэтгэврийн даатгал	32,567.3	32,567.3	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,445.8	22,445.8	-	100.0
Байрны түрээс	22,445.8	22,445.8	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	27,812.3	27,812.3	-	100.0
Бичиг хэрэг	5,593.1	5,593.1	-	100.0
Тээвэр, шатахуун	16,257.7	16,257.7	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,961.5	5,961.5	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,014.2	848.6	(165.6)	83.7
Багаж, техник, хэрэгсэл	506.5	506.5	-	100.0
Урсгал засвар	507.7	342.1	(165.6)	67.4
Томилолт, зочны зардал	12,560.8	12,560.8	-	100.0
Дотоод албан томилолт	12,560.8	12,560.8	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,898.1	83,882.2	(15.9)	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,288.1	72,288.1	-	100.0
Даатгалын үйлчилгээ	90.0	90.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	280.0	264.1	(15.9)	94.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	20.0	20.0	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,220.0	11,220.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,825.8	21,825.7	(0.1)	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,144.0	1,144.0	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,681.8	20,681.7	(0.1)	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
Улсын төсвөөс санхүүжих	498,189.9	498,008.1	(181.8)	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0

Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	-	100.0
Удирдах ажилтан	4	4	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100.0
Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	18	18	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	1	1	-	100.0